



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/015/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот	2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: <a href="mailto:atartsetsegm@audit.gov.mn">atartsetsegm@audit.gov.mn</a> Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: <a href="mailto:munkhboldbo@audit.gov.mn">munkhboldbo@audit.gov.mn</a>
------------------------------------------------------------------------------	---------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есенбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 21 № 62

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.МЯНГАНБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн газар зохион байгуулалтын 2024-2040 оны ерөнхий төлөвлөгөөг 650,807.5 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэх, аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу 13 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, газар зүйн нэрийн тодруулалт хийх зэрэг ажлуудыг хийсэн байна. Аймгийн хэмжээнд 87 барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаагийн 62 улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 3 гадаадын зээл тусламжаар, 22 хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна. Тайлант онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга угсралтаас 18, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй барилга угсралтаас 2, хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга угсралтаас 9 барилга, барилга байгууламжийн засварын ажил 1, нийт 30 төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал

8225020187

дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлого буюу хяналтын зардлаас 5,497.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан байна. Орон нутгийн төсвөөс 19,900.0 мянган төгрөгийн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас 5,860.0 мянган төгрөгийн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 14,122.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, нийт 45,379.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

### **Бусад асуудал**

Төсвийн захирагчийн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хяналт-шинжилгээ хийж, 91.84 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ТҮНЖИДМАА



## Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Аудитлагдсан	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>230,897,704.73</b>	<b>892,900,424.63</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	179,053,156.68	187,499,326.58
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,444,174.00	4,284,374.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	142,259,908.52	153,894,723.36
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	30,349,074.16	29,320,229.22
3351	Байгууллагаас авах авлага	1,601,239.16	572,394.22
3352	Хувь хүмүүсээс авах авлага	28,747,835.00	28,747,835.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	51,844,548.05	705,401,098.05
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	51,844,548.05	705,401,098.05
35410	Бичиг хэргийн материал	2,432,900.00	3,204,850.00
35420	Аж ахуйн материал	13,329,780.00	13,848,280.00
35430	Сэлбэг хэрэгсэл	15,061,100.00	16,137,100.00
35470	Бусад хангамжийн материал	21,020,768.05	672,210,868.05
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>493,516,297.35</b>	<b>474,680,987.04</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	493,516,297.35	474,680,987.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	468,704,214.08	450,113,903.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	356,145,100.00	356,145,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,885,171.96)	(63,014,706.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	142,800,000.00	142,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(88,550,000.00)	(109,550,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	339,296,243.44	383,316,751.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(233,532,571.88)	(261,985,980.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,234,518.92	22,234,518.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,864,529.76)	(19,831,780.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,830,000.00	3,830,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,769,374.68)	(3,830,000.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	24,812,083.27	24,567,083.23
39301	Програм хангамж	2,060,000.00	2,060,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,467,916.73)	(1,712,916.77)
39303	Бусад биет бус хөрөнгө	24,220,000.00	24,220,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>724,414,002.08</b>	<b>1,367,581,411.67</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,281,143.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	11,281,143.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	11,281,143.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	11,281,143.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	11,281,143.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>713,132,859.08</b>	<b>1,367,581,411.67</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	713,132,859.08	1,367,581,411.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	183,725,804.35	183,725,804.35
51101	Өмч: - төрийн	183,725,804.35	183,725,804.35
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	529,407,054.73	1,183,855,607.32
51210	Өмнөх үеийн үр дүн	420,607,933.18	529,407,054.73
51220	Тайлант үеийн үр дүн	108,799,121.55	654,448,552.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>724,414,002.08</b>	<b>1,367,581,411.67</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)


Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,148,483,311.21</b>	<b>2,281,728,291.99</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>237,419,837.19</b>	<b>802,912,530.47</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>237,419,837.19</b>	<b>802,912,530.47</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>234,617,625.05</b>	<b>802,912,530.47</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	234,210,609.52	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	407,015.53	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,802,212.14	111,767,954.84
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	691,144,575.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>911,063,474.02</b>	<b>1,478,815,761.52</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>853,992,000.00</b>	<b>1,270,467,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	853,992,000.00	1,270,467,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>56,112,474.02</b>	<b>208,348,161.52</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,499,402.30	29,367,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,613,071.72	178,980,661.52
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>959,000.00</b>	<b>0.00</b>
133003	Хөрөнгийн	959,000.00	0.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,039,684,189.66</b>	<b>1,627,279,739.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,039,684,189.66</b>	<b>1,627,279,739.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>985,592,701.09</b>	<b>1,425,397,858.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>673,997,792.74</b>	<b>944,903,285.65</b>
210101	Үндсэн цалин	433,332,084.30	553,546,600.58
210102	Нэмэгдэл	155,706,924.55	276,396,955.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,375,000.00	78,904,065.64
210104	Урамшуулал	42,678,410.50	36,055,663.90
210105	Гэрээт ажлын хөлс	8,905,373.39	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>85,710,117.19</b>	<b>120,361,529.17</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,627,986.50	83,381,417.02
210202	Тэтгэмжийн даатгал	7,146,810.07	9,622,051.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,524,942.07	4,759,325.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,360,069.31	4,505,175.62
210205	Эрүүл мэндийн даатгал	13,050,309.24	18,093,558.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,810,920.00</b>	<b>32,009,881.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,848,861.95	2,744,376.20
210302	Түлш, халаалт	19,813,418.05	25,297,145.03
210303	Цэвэр, бохир ус	3,148,640.00	3,968,360.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>51,287,369.12</b>	<b>22,819,572.52</b>
210401	Бичиг хэрэг	6,187,600.00	469,250.00
210402	Тээвэр, шатахуун	38,010,837.90	21,493,745.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	783,431.22	118,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	738,277.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,065,500.00	50,028,500.00
210408	Бараа материал акталсны зардал	0	0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>130,000.00</b>	<b>0.00</b>
210502	Хоол, хүнс	0	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	130,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,584,100.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	9,584,100.00	50,028,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>24,964,000.00</b>	<b>98,768,050.00</b>
210702	Дотоод албан томилолт	24,964,000.00	98,768,050.00

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,453,080.00</b>	<b>7,909,380.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,502,000.00	7,851,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,453,900.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,180.00	50,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	7,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	451,000.00	0.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>103,655,322.04</b>	<b>148,597,660.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,079,116.77	85,741,841.61
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,576,205.27	62,855,818.69
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,091,488.57</b>	<b>201,881,880.53</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>900,000.00</b>	<b>79,231,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	900,000.00	800,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	78431000
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>108,799,121.55</b>	<b>654,448,552.59</b>
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0</b>	<b>0</b>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	0
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>108,799,121.55</b>	<b>654,448,552.59</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,012,772,542.02</b>	<b>1,578,948,901.52</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>91,950,701.00</b>	<b>100,133,140.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>91,950,701.00</b>	<b>100,133,140.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>91,950,701.00</b>	<b>100,133,140.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	91,950,701.00	100,133,140.00
120009	Бусад орлого	-	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>920,821,841.02</b>	<b>1,478,815,761.52</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>853,992,000.00</b>	<b>1,270,467,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	853,992,000.00	1,270,467,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>66,829,841.02</b>	<b>208,348,161.52</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,216,769.30	29,367,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,613,071.72	178,980,661.52
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>987,522,742.02</b>	<b>1,573,451,651.52</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>987,522,742.02</b>	<b>1,573,451,651.52</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>933,431,253.45</b>	<b>1,371,569,770.99</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>680,034,951.21</b>	<b>942,743,485.65</b>
210101	Үндсэн цалин	439,369,242.77	551,386,800.58
210102	Нэмэгдэл	155,706,924.55	276,396,955.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,375,000.00	78,904,065.64
210104	Урамшуулал	42,678,410.50	36,055,663.90
210105	Гэрээт ажлын хөлс	8,905,373.39	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>87,311,356.35</b>	<b>119,332,684.23</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,229,225.66	82,352,572.08
210202	Тэтгэмжийн даатгал	7,146,810.07	9,622,051.80



210203	ҮОМШӨ-ний даатгал	5,524,942.07	4,759,325.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,360,069.31	4,505,175.62
210205	Эрүүл мэндийн даатгал	13,050,309.24	18,093,558.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,456,900.00</b>	<b>32,573,657.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,848,861.95	2,744,376.20
210302	Түлш, халаалт	19,813,418.05	25,297,145.03
210303	Цэвэр, бохир ус	2,794,620.00	4,532,136.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,647,979.41</b>	<b>23,225,772.52</b>
210401	Бичиг хэрэг	4,299,200.00	795,450.00
210402	Тээвэр, шатахуун	18,016,348.19	21,493,745.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	842,831.22	118,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	818,277.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,249,600.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>130,000.00</b>	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	130,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,597,180.00</b>	<b>50,028,500.00</b>
210604	Урсгал засвар	9,597,180.00	50,028,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>24,964,000.00</b>	<b>98,768,050.00</b>
210702	Дотоод албан томилолт	24,964,000.00	98,768,050.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,453,080.00</b>	<b>7,909,380.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,502,000.00	7,851,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,453,900.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,180.00	50,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	7,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	451,000.00	-
210807	Газрын төлбөр	-	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70,835,806.48</b>	<b>96,988,241.36</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,835,806.48	96,988,241.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,091,488.57</b>	<b>201,881,880.53</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>900,000.00</b>	<b>79,231,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	900,000.00	800,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	78,431,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>52,519,988.57</b>	<b>122,650,880.53</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,335,987.85	116,167,502.39
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	184,000.72	6,483,378.14
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>671,500.00</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	671,500.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>25,249,800.00</b>	<b>5,497,250.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Аудитлагдсан үлдэгдэл			
		Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	183,725,804.35	3,758,715.18	404,749,218.00	592,233,737.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	15,858,715.18	15,858,715.18
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,725,804.35	3,758,715.18	420,607,933.18	608,092,452.71
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(3,758,715.18)	-	(3,758,715.18)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	108,799,121.55	108,799,121.55
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,725,804.35	-	529,407,054.73	713,132,859.08
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	183,725,804.35	-	529,407,054.73	713,132,859.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,725,804.35	-	529,407,054.73	713,132,859.08
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	654,448,552.59	654,448,552.59
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,725,804.35	-	1,183,855,607.32	1,367,581,411.67

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,277,076,000.00	1,365,094,850.00	88,018,850.00	106.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,277,076,000.00	1,365,094,850.00	88,018,850.00	106.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,242,966,800.00	1,169,696,347.61	(73,270,452.4)	94.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	980,284,000.00	921,828,379.96	(58,455,620.00)	94.04
210101	Үндсэн цалин	527,415,000.00	551,386,800.58	23,971,800.60	104.55
210102	Нэмэгдэл	390,968,100.00	255,481,849.84	(135,486,250.20)	65.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,776,000.00	78,904,065.64	51,128,065.60	284.07
210104	Урамшуулал	34,124,900.00	36,055,663.90	1,930,763.90	105.66

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл</b>	122,535,500.00	116,463,246.29	(6,072,253.7)	95.04
210201	Тэтгэврийн даатгал	83,324,100.00	79,958,473.32	(3,365,626.7)	95.96
210202	Тэтгэмжийн даатгал	9,802,900.00	9,501,553.25	(301,346.8)	96.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,901,400.00	4,699,076.61	(202,323.4)	95.87
210204	Ажилгүйдлийн даатгал	4,901,400.00	4,446,741.35	(454,658.6)	90.72
210205	Эрүүл мэндийн даатгал	19,605,700.00	17,857,401.76	(1,748,298.2)	91.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,973,100.00	24,973,100.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,333,200.00	2,744,376.20	(588,823.8)	82.33
210302	Түлш, халаалт	19,416,300.00	19,831,243.80	414,943.8	102.14
210303	Цэвэр, бохир ус	2,223,600.00	2,397,480.00	173,880.0	107.82
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,798,200.00	4,769,750.00	(28,450.0)	99.41
210401	Бичиг хэрэг	823,900.00	795,450.00	(28,450.0)	96.55
210402	Тээвэр, шатахуун	3,414,900.00	3,414,900.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118,300.00	118,300.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	441,100.00	441,100.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	71,600.00	28,500.00	(43,100.0)	39.80
210604	Урсгал засвар	71,600.00	28,500.00	(43,100.0)	39.80
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,680,100.00	2,233,000.00	(447,100.0)	83.32
210702	Дотоод албан томилолт	2,680,100.00	2,233,000.00	(447,100.0)	83.32
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,062,000.00	2,412,130.00	(5,649,870.0)	29.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,851,300.00	2,354,050.00	(5,497,250.0)	29.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,000.00	50,380.00	(1,620.0)	96.88
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,700.00	7,700.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	99,430,000.00	96,988,241.36	(2,441,758.6)	97.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,430,000.00	96,988,241.36	(2,441,758.6)	97.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	34,109,200.00	195,398,502.39	161,289,302.4	572.86
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,109,200.00	79,231,000.00	45,121,800.0	232.29
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,736,200.00	800,000.00	(936,200.0)	46.08
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,373,000.00	78,431,000.00	46,058,000.0	242.27

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,277,076,000.00</b>	<b>1,370,600,740.00</b>	93,524,740.00	107.32
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,177,076,000.00	1,270,467,600.00	93,391,600.00	107.93
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,177,076,000.00	1,270,467,600.00	93,391,600.00	107.93
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	100,000,000.00	100,133,140.00	133,140.00	100.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000,000.00	100,133,140.00	133,140.00	100.13

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 А Аудитаар 131,853.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд байгууллагаас авах авлагын дүнг 572.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Санхүүгийн байдлын тайланд Бусад хангамжийн материалын дүнг 382.6 мянган төгрөгөөр, Үндсэн хөрөнгийн дүнг 1,359.3 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд Урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 102,866.8 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1,813.4 мянган төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардлыг 23,059.1 мянган төгрөгөөр, Дотоод албан томилолтын зардлыг 1,800.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 24,644.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 24,644.1 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 634.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 24,009.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 4 албан шаардлага өгсөн.

### 5.2 Төлбөрийн акт

- Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 634,600.00 (Зургаан зуун гучин дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан олгосон цалинг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

### 3.3 Албан шаардлага

1. Томилолтын удирдамж, илтгэх хуудасгүй, явсан ирсэн огноогүй, дарга, нягтлан бодогчийн олгох зөвшөөрөлгүй зэрэг зөрчилтэй 10,810,000.00 (арван сая найман зуун арван мянган)

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн албан томилолтын зардал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөн төлбөр олгоно" гэж заасантай нийцэхгүй байна. гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын мөнгийг анхан шатны бүрдэл болсон баримтыг үндэслэн зохих журмын дагуу олгох албан шаардлага хүргүүлсэн.

2. Улирлын урамшууллыг 2,635.0 (Хоёр сая зургаан зуун гучин таван мянган) төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна". 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улирлын урамшууллыг зохих журмын дагуу үнэлж, дүгнэж, давхардуулахгүйгээр олгох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын захиалагчийн техник хяналтын зардлын тооцоог нийлж баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын захиалагчийн техник хяналтын зардлын тооцоог нийлж баталгаажуулж, хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4. Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн үйл ажиллагааны баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний зардлуудаас эдгээр зардалд хамаарахгүй үйл ажиллагааны 10,564.0 мянган төгрөгийн албан томилолтыг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" Барилга, хот байгуулалтын Сайдын "Барилга захиалагчийн хяналтын талаар авах арга хэмжээний тухай" 2022.04.11-ний өдрийн №83 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл"-ийн 1.-д Барилга байгууламжийн захиалагчийн хяналт хийхтэй болбогдон гарах гэрээт, инженер, техникийн ажилтан, барилгын материалын шинжээч болон лаборантын ажлын хөлс, урамшуулал, албан томилолтын зардал; Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын "Харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлогын зарцуулалтын талаар авах арга хэмжээ" 2024.03.18-өдрийн А/83 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн үйл ажиллагааны баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний зардлын нэр төрөл"-ийн Эдийн засгийн ангиллын 2-т Эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, солбилцуулах, газрын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тээвэр шатахуун, томилолт, автомашины сэлбэг хэрэгслийн зардал" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн үйл ажиллагааны баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний зардлуудаас журамд заасан зардлыг зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тайлантай холбоотой асуудал


Илрүүлэлт:

Цалинг нийгмийн даатгалын тайлангаас 8,178.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна"

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцож, хууль, журмыг үнэн зөв мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье



**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**  
**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2 Санхүүгийн байдлын тайланд байгууллагаас авах авлагын дүнг 572.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Газрын харилцаа, хот барилга, хот байгуулалтын газар	Бусад хангамжийн материалын дүнг 382.6 мянган төгрөгөөр, Үндсэн хөрөнгийн дүнг 1,359.3 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.	1	572.4	-	-	1	572.4	1	572.4	-	-	-	-
	Санхүүгийн үр дүнгийн тайланд Урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 102,866.8 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1,813.4 мянган төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардлыг 23,059.1 мянган төгрөгөөр, Дотоод албан томилолтын зардлыг 1,800.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.	1	1,741.9	-	-	1	1,741.9	1	1,741.9	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>131,853.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>131,853.7</b>	<b>3</b>	<b>131,853.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн											
		Үүнээс:											
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн					
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
	Томилолтын удирдамж, илтгэх хуудасгүй, явсан ирсэн огноогүй, дарга, нягтлан бодогчийн олгох зөвшөөрөлгүй зэрэг зөрчилтэй 10,810.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон.	1	10,810.0	-	-	1	10,810.0	-	-	-	-		
	Цалинг нийгмийн даатгалын тайлангаас 8,178.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	-	-	-	-	-	1	-	-	-		
	Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 634.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	634.6	1	634.6	-	-	-	-	-	-		
Газрын харилцаа, хот барилга, хот байгуулалтын газар	Улирлын урамшууллыг 2,635.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.	1	2,635.0	-	-	1	2,635.0	-	-	-	-		
	Орон хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын захиалагчийн техник хяналтын зардлын тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-		
	Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн үйл ажиллагааны баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний зардлуудаас эдгээр зардалд хамаарахгүй үйл ажиллагааны 10,564.0 мянган төгрөгийн албан томилолтыг олгосон.	1	10,564.0	-	-	1	10,564.0	-	-	-	-		
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>24,644.1</b>	<b>1</b>	<b>634.6</b>	<b>4</b>	<b>24,009.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>		



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтий	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			

